


СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТУХАЙ

ON THE RIGHTS OF HEARING IMPAIRMENT CITIZENS

**М.Анхбаяр**

*Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй-Нийгмийн ухааны сургуулийн
233 дугаар дамжааны оюутан*

Товч утга: Сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ өөрт хэрэгцээтэй үйлчилгээгээ авч чадахгүй байна. Учир нь төрийн албан хаагчтай ойлголцоход хэцүү, буруу, дутуу ойлголцох гэх зэрэг хүндрэл бэрхшээл ихээхэн тулгарч байна.

Түлхүүр үгс: Хүний эрх, тусгай хэрэгцээ, сонсгол алдагдал, төрийн үйлчилгээ.

Abstract: Hearing impaired citizens cannot get the services they need when they use public institutions. Because it is difficult to understand with the employee, there are a lot of difficulties such as misunderstanding.

Keywords: Human rights, special needs, hearing loss, services of public institutions.

Бид эмнэлэгт үзүүлэхдээ тухайн эмчдээ өөрийн биеийн аль хэсэг хаана өвдөж байгаагаа хэлж эмчтэй харилцан ойлголцсны үндсэн дээр эмч миний биеийн өвдөж байгаа хэсгийг үзэж оношлон шаардлагатай эмчилгээ хийж, зөвлөгөө өгч, эм бичиж өгдөг. Би эмчтэй харилцан ойлголцсоны улмаас өөрийн биеийн аль эрхтэн юунаас болж өвдсөн тухайгаа мэдэж эмчийн зөвлөсний дагуу эмчилгээгээ хийлгэнэ ээ. Хэрэв эмчтэй харилцан ойлголцож чадахгүй бол өөрийн биеийн аль эрхтэн юунаас болж өвдсөн тухайгаа ч мэдэх боломжгүй бөгөөд цаашлаад ямар эмчилгээ үйлчилгээ хийлгэхээ ч мэдэх боломжгүй болно. Тиймээс бид бие биетэйгээ аман болон аман бус байдлаар ойлголцож байж л нийгмийн харилцаанд бие даан оролцох боломж бүрдэж байна.

Сонсголын бэрхшээлтэй хүмүүс төрийн байгууллагаар ганцаарчлан үйлчлүүлэхдээ тухайн байгууллагын ачаалалтай байдлаас шалтгаалан харилцаж буй албан хаагчтай ойлголцох боломж хомс, буруу, дутуу ойлголцох, өөрийн хүссэн үйлчилгээгээ авч чадахгүй байх зэрэг асуудал тулгарч байна. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дэх хэсэгт “Төрийн байгууллага,

албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.”, 16 дугаар зүйл 16 дахь хэсэгт “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловслоороор нь ялгавларан гадуурхаж үл болно”²²⁵ гэж хуульчилсан байдаг хэдий ч дээрх иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх зөрчигдөж байна.

Сонсголын бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлын талаар маш олон хэлбэрээр ярьдаг хэдий ч яг хэрэгжээд шийдвэрлэгдсэн асуудал тун цөөн юм. Энэхүү байдал тэднийг үл хайхрах гэсэн хүчирхийллийн нэг төрөлд өртөж байгааг харуулж байна. Тэд өөрийн эх орондоо амьдарч байгаа хэдий ч харь улсад амьдарч байгаа мэт бусадтай ойлголцох ямар нэгэн өөрт хэрэгцээтэй үйлчилгээ авах боломж нөхцөл нь маш хүндрэлтэй байна гэж үзэж байгаа тул энэхүү асуудлаар цааш судлах шаардлагатай гэдэг үүднээс “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” сэдэвт илтгэлээ бичихээр болсон. Сонсголын бэрхшээлийн талаар хүмүүс ихэнх нь буруу ойлголттой байдаг учраас энэхүү илтгэлээрээ илүү дэлгэрэнгүй судлан орууллаа.

Сонсголын бэрхшээлийн тухай ойлголт

Хүний үндсэн 5 мэдрэхүйн нэг нь сонсох билээ. Чихний үүрэг бол зөвхөн мэдээлэл хүлээн авагч бус түүнийг илэрхийлэх буюу хэл яриатай холбоотой. Хүний сонсгол хэвийн байснаар бусадтай харилцан ойлголцоход хүндрэлгүй байна.

Тэгвэл сонсгол гэдэг нь тархин дахь сонорын төв нь гадны дуу авианы хэлбэлзлийг сонсгол дамжуулах эрхтний тусламжтайгаар хүртэн хүлээж авч, гаднах орчинтой харилцахад хэрэглэдэг чадвар юм. Чих нь сонсох мэдрэхүйн дамжуулагч бөгөөд ерөнхий бүтцээрээ гадна, дунд, дотор гэж 3 хуваагдана. Бидний нүдэнд харагдаж байгаа чихний дэлбээнээс хэнгэрэг хүртэлх хэсгийг гадна чих гэж нэрлэдэг бөгөөд дууны долгионыг цуглуулаад дунд чихэнд дамжуулах үүрэгтэй. Хэнгэрэгнээс цааш дотор чих хүртэл хэсгийг дунд чих гэдэг бөгөөд хүний биед байдаг алх, дөш, дөрөө гэж нэрлэдэг хүний биеийн хамгийн жижиг 3 яснаас бүрдэг. Дунд чих нь гаднаас орж ирсэн дууны долгионд цохигдсон хэнгэрэгний доржилтыг дотор чихэнд дамжуулдаг. Дотор чих нь 3 ширхэг хагас цагираг агуулсан дунд хэлбэртэй яс бөгөөд энэ нь шингэн болон дууны долгион мэдрэгч мэдрэлийн ширхэгийг агуулж байдаг. Дунд чихнээс ирсэн дууны долгион дотор чихэн дэхь шингэнийг цалгиулж хөдөлгөөнд оруулахад мэдрэлийн ширхэг нь цочирч, дууны долгионыг тархи руу дамжуулдаг. Тархи тэр мэдээллийг хүлээн

²²⁵ Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1. 16 дугаар зүйлийн 12, 16 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

авснаар дуу чимээг ялган боловсруулж, хариу үйлдэл хийдэг. Дээрх хэвийн үйл явц алдагдсанаас шалтгаалан муу дутуу сонсох, огт сонсохгүй байхыг сонсголын бэрхшээл гэж нэрлэдэг.

Сонсголын бэрхшээл: Аливаа гэмтэл, өвчлөлийн улмаас сонсголыг дамжуулах эрхтэн болох чих нь үүргээ гүйцэтгэж чадахгүй болсны улмаас сонсголын алдагдал буюу сонсголын бэрхшээл бий болдог.

Сонсголын бэрхшээлтэй хүн: - Сонсох эрхтний аливаа нэг гэмтэл, өвчлөлийн улмаас эсвэл удамшлын шалтгаанаар сонсголын эрхтэн өөрийн үүргээ ямар нэг хэмжээгээр гүйцэтгэж чадахгүй болсноос хүний хэл яриа хөгжөөгүй буюу хөгжих бэрхшээлтэй болсон, бие дааж хэл яриа эзэмших, хэл яриагаа сонсголын замаар хөгжүүлэх чадваргүй болсон хүнийг хэлнэ²²⁶.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүний сонсгол алдагдлын түвшинг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хүснэгт.№1

д\д	Сонсгол алдагдлын хэмжээ /децибел-дб/	Хөгжлийн бэрхшээлийн түвшин
1.	25db- доош	Хэвийн /normal/
2.	26-40 db	Хөнгөн /mild/
3.	41-55 db	Дунд зэрэг /middle/
4.	56-70 db	Хүндэвтэр /middle- severe/
5.	71-90 db	Хүнд /severe/
6.	90 db- с дээш	Маш хүнд / profound/

Сонсгол алдагдлын төрлүүд:

-  дамжуулалтын алдагдал
-  мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал
-  холимог хэлбэрийн алдагдал гэсэн төрлүүдтэй.

Дамжуулалтын алдагдал: гадна болон дунд чихээр дамжуулах дуу чимээний долгионыг ямар нэг зүйлс саатуулж зогсоохыг хэлнэ. Дууны долгион дотор чихэнд хүрч очихын тулд чихний суваг цэвэрхэн байх, чихний хэнгэрэг зөв цочрол өгч чадахуйц байх, мөн жижиг яснууд нь зүй ёсоороо цочирч байхын тулд дунд чихний хөндий агаараар дүүрсэн байх ёстой. Дамжуулагчийн алдагдал нь дараах шалтгаанаас үүсдэг. Үүнд:

- ✓ хулхи эсвэл өөр бусад зүйлс чихний сүвийг бөглөх
- ✓ чихний хэнгэрэгний хальсны цооролт

²²⁶ <https://apdc.mn/>

- ✓ дунд чихэнд хуралдсан шингэн
- ✓ жижиг яс байхгүй гэх хөгжилтэй гэх мэт

Дамжуулалтын алдагдал нь дотор чихэнд хүрч очиж буй дуу чимээний тоо хэмжээнд нөлөөлдөг, ийм төрлийн алдагдалтай хүмүүст дуу чимээ сул мэт санагдах, зарим дуу чимээ огт сонсогдохгүй гэсэн үг. Ихэнх тохиолдолд энэхүү алдагдал нь түр зуурынх байдаг бөгөөд үүнийг анагаах ухаанд эмчилдэг.

Мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал: энэ нь чихний дундах мэдрэлийн эсүүд эсвэл сонсголын мэдрэлүүд нь бүрэн гүйцэт ажиллахгүй үед бий болдог. Мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал нь доорх шалтгаанаас үүдэлтэй байна. үүнд:

- ✓ удамшлын хүчин зүйлс
- ✓ өвчин
- ✓ удаан хугацааны турш чанга дуу чимээнд байсан
- ✓ өндөр нас

Мэдрэлийн гаралтай сонсгол алдагдал дууны тоо хэмжээ чанар хоёуланд нь нөлөөлдөг. Энэ нь дуу маш тод сонсогдох боловч зарим нь огт сонсогдохгүй энэ төрлийн алдагдал энэ үедээ эмчлэгддэггүй учир тогтсон гэж үздэг.

Холимог хэлбэрийн алдагдал: энгийнээр хэлэхэд энэ нь дамжуулагчийн гаралтай болон мэдрэлийн гаралтай сонсголын алдагдлын аль аль нь бий болсныг ойлгоно²²⁷.

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны хэлбэр: Үндэсний статистикийн хорооноос авсан судалгаагаар манай улсад сонсголын бэрхшээлтэй 8430 хүн байдаг гэсэн тоон судалгаа байдаг²²⁸. Эдгээр хүмүүс нийгмийн харилцаанд орохдоо бусадтай хэрхэн ойлголцох боломжтой вэ? Эх хэл гэдэг бол аливаа улс үндэстний оршин тогтнох, үндэсний онцлогоо харуулах нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хувь хүний боловсрол олж авах, нийгэмд өөрийн байр сууриа бий болгоход чухал үүрэгтэй байдаг. Тэгвэл сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд дохионы хэл нь тэдний эх хэл юм. Шинжлэх ухаанд дохионы хэл гэдгийг дактилология буюу хурууны үсэг болон дохио зангааны хэл гэсэн 2 том бүрэлдэхүүн хэсэгт хувааж хараагаараа хүлээн авах хэлний нэг томоохон салбар болгон судалж ирсэн байна. Хүний гар хуруу нь дохиог илэрхийлэх гол хэрэгсэл болно. Дэлхийн сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбооноос дохионы хэлийг сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдүгээр хэл хэмээн тунхагласнаар улс орон бүр өөрсдийн дохионы хэлийг бий болгон хөгжүүлж иржээ. Хэдийгээр монгол дохионы хэл нь монгол хэл шиг олон зуун жилийн төгс хөгжил, баялаг өв сангүй боловч аль тэртээ дөч гаран жилийн өмнө сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд

²²⁷ <https://apdc.mn/>

²²⁸ <https://www.1212.mn/>

ерөнхий боловсрол олгох тусгай сургууль байгуулагдсан тэр цагаас монгол дохионы хэл бүрэлдэн бий болох үндэс суурь нь тавигдаж, өдгөө сонсголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны гол хэрэглүүр болж, дохионы сан, хэл зүй, өгүүлбэр зүйн тогтсон дүрэмтэй, бие даасан нэг хэл болон бүрэлдэж чадсан байна²²⁹.

Сонсголгүй хүн бусдын л адил оюун ухаан, сэтгэн бодох чадвартай. Гэвч зөвхөн сонсох чадваргүйгээсээ болж нийгмийн харилцаанд орох, төрийн үйлчилгээ авах, цагдаа хууль хяналтын байгууллагаар үйлчлүүлэх үед сонсголын бэрхшээлээсээ болж өөрсдийгөө илэрхийлж чаддаггүй зэрэг өдөр тутмын нийгмийн харилцаанд нь асуудал тулгарч байна. Энэ нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх буюу Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 хэсэгт “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, мөн хуулийн 16-р зүйлийн 12 дэх хэсэгт “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх”²³⁰ тус тус хязгаарлагдаж зөрчигдөж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн хаагчтай ойлголцоход хүндрэл бэрхшээлтэй байдаг учраас өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй. Мөн өөрт тулгарч буй асуудлаа шийдвэрлүүлэх боломж хомс гэж үзэж байна. Учир нь төрийн байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцаж ойлголцдог хэлмэрч байхгүй, төрийн албан хаагчид нь тодорхой хэмжээний дохионы хэл мэдэхгүй байгаа нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө зөрчигдөх нэг томоохон нөхцөл болж байна.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй”, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ”²³¹ гэж хуульчилсан байдаг бөгөөд энэхүү хууль нь бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна. Сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилгоор дараах судалгааг авлаа.

²²⁹ <http://tsagtur.mn/>

²³⁰ Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1. 16 дугаар зүйлийн 12, 16 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

²³¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. УБ. 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9. 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

Энэхүү судалгаанд 1600 гишүүнтэй “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн групп”, 1100 гишүүнтэй “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төв ТББ” пэйж хуудсын 23 гишүүн оролцсон.



- 1 хүн буюу 4% нь 91-с дээш дб-н сонсгол алдагдалтай байна.



Зураг№1

Нийт судалгаанд оролцогчдын сонсгол алдагдлын түвшинг харуулав.


- 5 хүн буюу 22% нь 26-55 дб-н сонсгол алдагдалтай байна.
- 10 хүн буюу 44% нь 56-70 дб-н сонсгол алдагдалтай байна.
- 7 хүн буюу 30% нь 71-90 дб-н сонсгол алдагдалтай байна.

Зураг№2

Судалгаанд 22-55 насны хүн оролцсоноос

- 21 буюу 91% нь эмэгтэй
- 2 буюу 9% нь эрэгтэй байна. Үүнээс дүгнэхэд эрэгтэй иргэдийн хувьд оролцоо бага байдаг нь харагдаж байна.

Зураг №3



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар нэгэн хүндрэл гардаг уу? гэсэн асуултанд бүгд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар нэгэн хүндрэл гардаг гэж хариулсан байна.

Зураг №4




Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар хүндрэл гардаг вэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариуллаа.

- 7 буюу 30% нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ойлголцоход хүндрэлтэй байдаг.

- 16 буюу 70% нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд дээрх бүгд асуудал тулгардаг гэж

хариулжээ. Үүнээс дүгнэхэд сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд зөвхөн ойлголцоход хэцүү байдаггүй түүнээс шалтгаалан өөр хүндрэл бэрхшээлүүд гардаг байх нь харагдаж байна.

Зураг№5 Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага хүссэн




үйлчилгээгээ авахал саад учруулдаг уу? гэсэн асуултанд дараах байдлаар хариулжээ.

- 14 буюу 61% нь төрийн албан хаагчдын харилцаа хандлага нь хүссэн үйлчилгээгээ авахад саад учруулдаг гэж хариулсан

- 9 буюу 39% нь төрийн албан хаагчдын харилцаа хандлага нь хүссэн үйлчилгээгээ авахад заримдаа саад учруулдаг гэж хариулсан байна. Үүнээс

дүгнэхэд сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчдын харилцаа хандлага ч мөн тэдний хувьд тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Зураг№6



Төрийн албан хаагчид тодорхой хэмжээний дохионы хэл мэддэг бол таньд үйлчилгээ авахад хялбар байж чадах уу? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчид тийм гэж хариулжээ.

Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд таньд тулгамдаж буй асуудал гэсэн асуулгын хувьд судалгаанд оролцсон иргэдийг өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох үүднээс нээлттэй байдлаар

авсан. Судалгаанд оролцсон иргэдийн хувьд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ойлголцоход хэцүү, хүнд суртал их, хэлмэрч байдаггүй, бичгээр ойлголцоход хэцүү байдаг учраас өөрийн хүссэн үйлчилгээгээ авахад хэцүү байдаг гэж хариулсан байна.

Дүгнэлт

Иргэдэд ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй, бүгдэд хүртээмжтэй, тэгш үйлчлэх цорын ганц байгууллага бол төрийн байгууллага юм. Түүний нэг болох

нэг цэгийн үйлчилгээ буюу төрийн олон төрлийн үйлчилгээг нэг дор үзүүлдэг байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд олон хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Тиймээс өөрийн илтгэлдээ сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл асуудлуудтай тулгардаг талаар судлан өөрийн авсан бяцхан судалгаагаар нотлон харуулахыг хичээлээ.

Нэг үеэ бодоход төрийн байгууллага сонсголын бэрхшээлтэй иргэдэд тулгардаг асуудлын талаар мэддэг болсон бөгөөд телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл дамжуулахдаа дохионы хэлээр давхар хүрэгдэг болсон нь сайшаалтай. Гэхдээ сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ заавал гэр бүл, төрөл садангийн хэн нэгэнтэй цуг явах эсхүл өөрийн өмнөөс төлөөлүүлэх байдлаар үйлчилгээ авч байна. Учир нь сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчтай ойлголцоход хэцүү байдаг учраас өөрийн хүссэн үйлчилгээгээ түргэн шуурхай авах, сэтгэл ханамжтай байдлаар авч чаддаггүй байна. Энэ нь төрийн байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах хэлмэрч байхгүй, төрийн албан хаагчид нь тодорхой хэмжээнд дохионы хэл мэддэггүйтэй холбоотой байна.

Үүнээс үүдэн сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд Монгол улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиудаар олгогдсон эрх, эрх чөлөө нь хязгаарлагдаж, зөрчигдөж байна. Тиймээс сонсголын бэрхшээлтэй иргэдэд хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

Санал

1. Төрийн албан хаагчдыг тодорхой хэмжээний дохионы хэлний мэдлэгтэй болгох. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй иргэдтэй ойлголцоход дөхөм болох бөгөөд тухайн иргэд төрийн үйлчилгээг бие даан авахад хялбар болно;
2. Төрийн байгууллага бүр дохионы хэлмэрчтэй болох. Сонсголын бэрхшээлтэй иргэд ямар нэгэн саадгүйгээр эрхээ эдлэх боломж нээгдэнэ;
3. Төрийн бүх салбар байгууллагууд сонсголгүй иргэдэд зориулсан мэдээ, мэдээллийг хүртээмжтэй хүргэх;
4. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх боломжийг нээж өгөх үүднээс тэдгээрт үйлчилдэг дохионы хэлний мэдлэгтэй албан хаагчийг тусгайлан бэлдэж ажиллуулах;
5. Төрийн үйлчилгээг хүргэхдээ техник, технологи ашиглан мэдээлэл дамжуулах, тусгай хэрэгцээт иргэдэд тусламж, дэмжлэг шууд хүргэх, тэд мэдээлэл шууд авах боломжийг бүрдүүлэх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. 2016 он
3. <https://apdc.mn>
4. <http://tsagtur.mn/>
5. <https://legalinfo.mn/>

---o0o---